



## “МИЛАЯ ФҮҮДС” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А-01/54

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3 дугаар зүйлий 3.1-г үндэслэн  
ТУШААХ нь:

1. Милая фүүдс ХХК-ийн “Ажилтанд сургалтын тэтгэлэг олгох журам”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. “Ажилтанд сургалтын тэтгэлэг олгох журам” батлагдсантай холбогдуулан Маркетингийн менежер /Б.Буяндэлгэр/-т компанийн ажилтнуудад ил тодоор мэдээлэл хүргүүлэхийг үүрэг болгосугай.

3. Батлагдсан журмыг нийт ажилтнуудад танилцуулан цаашид мөрдүүлж ажиллахыг Хүний нөөцийн менежер /Б.Нандинзаяа/, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий менежер /Э.Мөнхнаран/-д тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.ЭНЭРЭЛ

## **“МИЛАЯ ФҮҮДС” ХХК-ИЙН АЖИЛТАНД СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ**

### **1. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, үндэсний их, дээд сургууль, сургалтын байгууллага (цаашид "сургалтын байгууллага" гэх)-д зохих журмын дагуу элсэн суралцаж байгаа компанид тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж буй ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх сургалтын төлбөр (цаашид "тэтгэлэг" гэх) олгохтой холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.2. Тэтгэлгийн зорилго хүний нөөцийн эргэцийг бууруулах, компанийн ажилтнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд оршино.
- 1.3. Тэтгэлэг олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.
- 1.4. Тэтгэлэгт энэ журмын 2.1-т заасан шаардлагыг хангасан ажилтан; түүний төрсөн болон үрчлэн авсан хүүхдийг хамруулна.

### **2. Тэтгэлгийн шаардлага**

- 2.1. Дараах шаардлага хангасан ажилтанд тэтгэлэг олгоно.
  - 2.1.1. Тухайн мэргэжил, мэргэшил дээшлүүлэх сургалтаар олж авах мэдлэг, ур чадвар, үр дүн компанийн хэрэгцээ шаардлагатай нийцсэн байх тухай шууд удирдлага тодорхойлсон байх;
  - 2.1.2. Ажил олгогчоос тухайн ажилтныг мэргэжил эзэмших, мэргэжлийн зэрэг дээшлүүлэхийг дэмжсэн байх;
  - 2.1.3. Тэтгэлэг горилогч компанид 3-аас доошгүй жил ажилласан байх;
  - 2.1.4. Их дээд сургуулийн бакалавр, магистр; Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон мэргэжлийн үнэмлэх олгох сургалтын төвд сурахаар тэнцсэн байх;
  - 2.1.5. Зайлшгүй шаардлагатай гэж үзсэн ажилтанг Милая Фүүдс ХХК-ийн Үүсгэн байгуулагчийн шийдвэрээр тэтгэлэг олгоно.
- 2.2. Дараах шаардлага хангасан ажилтны төрсөн болон үрчлэн авсан хүүхдэд сургалтын төлбөрийн тэтгэлэг олгож болно.
  - 2.2.1. Ажилтны төрсөн болон үрчлэн авсан хүүхэд 23 буюу түүнээс доош настай байх;
  - 2.2.2. Их дээд сургуулийн 2 буюу түүнээс дээш дамжаанд суралцдаг байх;

### **3. Тэтгэлгийн сонгон шалгаруулалт**

- 3.1. Тэтгэлэгт хамрагдах иргэний сонгон шалгаруулалтыг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан ажлын хэсэг зохион байгуулна.
- 3.2. Сонгон шалгаруулалтыг тухайн жилийн 8 дугаар сард багтаан зохион байгуулна.
  - 3.2.1. Сонгон шалгаруулалтын анкетыг 2023 оны 08 дугаар сарын 01-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдөр 18:00 цаг хүртэл хүлээн авна

- 3.2.2. 2023 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор сонгон шалгаруулалтын хариуг өгнө.
- 3.3. Ажлын хэсгийн нийт гишүүдийн олонхын саналд үндэслэн шийдвэр гаргах ба тэтгэлэг олгох эсэх, олгох тэтгэлгийн хэмжээг Гүйцэтгэх захирал эцэслэн баталж, тушаал гаргана.
- 3.4. Тэтгэлгийн зарыг сонгон шалгаруулалт зохион байгуулахаас 30 хоногийн өмнө Захиргаа хүний нөөцийн албанаас ил тод, нээлттэй зарлана.
- 3.5. Тэтгэлэгт хамрагдахыг хүссэн иргэн энэ журмын 2.1-т заасан шаардлагыг хангасан гэдгийг нотлох баримт бичгийг сонгон шалгаруулалт зарласан хугацаанд “Милая Фүүдс” ХХК-ийн Захиргаа хүний нөөцийн албаны ажилтанд өгнө.
- 3.6. Сонгон шалгаруулах үйл ажиллагааг ажилтан болон түүний хүүхдийн ирүүлсэн холбогдох баримт бичигт үндэслэн зохион байгуулах бөгөөд хугацаа хожимдуулсан, баримт бичгийн бүрдүүлэлт дутуу тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.
- 3.7. Сонгон шалгаруулалтад ирүүлэх бичиг баримтын жагсаалт
- 3.7.1. Иргэний үнэмлэхийн лавлагаа
  - 3.7.2. Оршин суугаа хаягийн лавлагаа
  - 3.7.3. Анкет
  - 3.7.4. Төрсний гэрчилгээний лавлагаа
  - 3.7.5. Тэтгэмжийн шалгуурыг хүлээн зөвшөөрсөн хүсэлт
  - 3.7.6. Ажилтан тухайн сургаальд тэнцсэн тухай тодорхойлолт
  - 3.7.7. Ажилтны хүүхэд бол суралцаж буй сургуулийн тодорхойлолт мөн Е-монголиа цахим сангаас оюутны үнэмлэхний хуулбар

#### **4. Тэтгэлэг олгох**

- 4.1. Тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн ажилтан, эсхүл түүний төрсөн болон үрчлэн авсан хүүхдэд дараах тэтгэлэг олгоно:
- 4.1.1. Энэ журмын 2.1-т заасан шаардлагыг хангасан 10 хүртэлх ажилтан, түүний хүүхдэд тухайн жилийн сургалтын төлбөрийн 30-70 хувь хүртэл хувийн тэтгэлэг;
- 4.2. Тэтгэлгийг шалгарсан ажилтны суралцаж буй сургалтын байгууллагын дансанд шилжүүлэх бөгөөд тэтгэлэгт хамрагдсан иргэн төлбөрийн И-баримтыг Милая Фүүдс ХХК-ийн нэр дээр шивүүлэх үүрэг хүлээнэ.

#### **5. Тэтгэлгийн хариуцлага**

- 5.1. Тэтгэлгийн нөхцөлийг хангаж, гүйцэтгэх захирлаас дэмжсэн ажилтантай Милая Фүүдс ХХК-ийн Захиргаа хүний нөөцийн албаны хариуцсан ажилтан гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 5.2. Сонгон шалгаруулалтад тэнцэж тэтгэлэгт хамрагдсан ажилтан болон түүний хүүхэд эрүүл мэндийн шалтгаанаас бусад шалтгаанаар суралцаагүй тохиолдолд компаниас санхүүжүүлсэн санхүүжилтийг компанид буцааж бүрэн төлнө. Эрүүл мэндийн шалтгаанаар суралцах боломжгүй болсныг эрүүл мэндийн эрх бүхий байгууллагын тодорхойлолтоор нотолно.
- 5.3. Тэтгэлэг авсан ажилтан; тэтгэлэг авсан /ажилтны/ хүүхэд анх гэрээ байгуулахад сонгосон мэргэжлээ солих тохиолдолд тухайн хугацаанд авсан тэтгэлэгийг компанид буцаан бүрэн төлнө.

- 5.4. Тэтгэлэг авсан ажилтан; хүүхдээ тэтгэлэгт хамруулсан ажилтан тухайн Сургалтын тэтгэлгийн гэрээ байгуулснаас хойш компанид 2 жил ажиллах үүрэг хүлээнэ. Журмын дагуу үүрэг хүлээсэн хугацаанд ажиллаагүй тохиолдолд авсан тэтгэлгийг хоёр нугалсан хэмжээгээр компанид буцаан бүрэн төлнө.
- 5.5. Өөр байгууллагаас адил тэтгэлэг аваагүй байх;

## 6. Бусад

- 6.1. Тэтгэлэгтэй холбогдуулж сонгон шалгаруулалтад ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн, баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, суралцагчийн мэдээллийг буруу гаргасан буюу сурлагын үнэлгээг бодитой бус үнэлсэн нь тогтоогдвол гомдлыг гүйцэтгэх захирал хянаж шийдвэрлэнэ.
- 6.2. Энэхүү журам нь гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх ба шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг гүйцэтгэх захирал тушаал гаргаж шийдвэрлэнэ.